



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 24 өдөр

Дугаар А/673

Булган сум

**Мотоциклиор замын хөдөлгөөнд оролцохыг  
түр хугацаанд хориглох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Хүйтний улирал эхэлж замын зорчих хэсгийн гадаргуу цас, мөсөөр хучигдан, халтиргаа, гулгаа үүссэн нөхцөлд мотоциклиор замын хөдөлгөөнд оролцогчдын болон бусдын эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насанд учрах осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн нутаг дэвсгэрт мотоциклиор замын хөдөлгөөнд оролцохыг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал түр хугацаанд хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга, сэрэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан захирамжид тусгагдсан үйл ажиллагааны үр дүнг аймгийн Засаг даргад 2026 оны 4 дүгээр сарын 10-ны дотор танилцуулахыг Цагдаагийн газрын дарга (цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



0325010946